

Санхүүгийн хүртээмж

Санхүүгийн урсгалыг нээж, бичил уурхайд өөрчлөлт авч ирэх нь

Алтны бичил уурхай нь бусад салбартай харьцуулбал эргэлтийн хөрөнгө багатай байдаг. Бичил уурхайчны нэг грамм алтанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ нь том уурхайн нэг грамм алтанд оруулсан хөрөнгө оруулалттай харьцуулахад маш бага.

Бичил уурхай дахь алт олборлолт болон баяжуулалтын үйл ажиллагаанд хөрөнгө оруулах нь эрсдэл өндөртэй гэх хандлага түгээмэл байсан ч өнөө үед нөхцөл байдал өөрчлөгдөж байна. Энэ нь нэг талаас алтны зах зээлд хэрэглэгчдийн тоо ихсэж байгаа, нөгөөтээгүүр хувийн хэвшлийн зүгээс хариуцлагатай олборлосон бичил уурхайн алтны эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбоотой юм.

Алтны бичил уурхайн хөрөнгө оруулалтын үндсэн ойлголтууд

planetGOLD хөтөлбөр нь алтны бичил уурхайг байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай болгох зорилгоор энэ төрлийн хөрөнгө оруулалтын боломжуудын талаарх бодит, үнэн зөв мэдээллийг санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон хөрөнгө оруулагчдад хүргэхийн сацуу бичил уурхайчид өөрийн үйл ажиллагааны тухай мэдээллийг хөрөнгө оруулагчдад зориулан боловсруулж, танилцуулахад нь туслалцаа үзүүлж байна.

Санхүүжилтийн урсгалыг нээхийн тулд хөрөнгө оруулагчид, бичил уурхайчдын хэрэгцээнд нийцсэн бодит үр ашигтай бизнес кейс эн тэргүүнд хэрэгтэй болно. Энэхүү бизнес кейсийг гаргаж ирэхийн тулд тэдний хэрэгцээ шаардлагуудыг ойлгон судалж, түүнд тохирсон боломжуудыг бий болгох нь чухал.



Бичил уурхайчдын үндсэн хэрэгцээ

Хэрэгцээ

Тогтмол орлоготой байх

Хандлагаа өөрчлөх нөхцөл боломж

Үйл ажиллагаа эрхлэх боломжтой болох

ХАБЭА-н шаардлагад нийцэх

Итгэлт хамтрагч нар

Бэрхшээл

Тогтмол бус орлого

Хандлагаа өөрчлөх нөхцөл боломж байхгүй

Үйл ажиллагаа эрхлэх нөхцөл байдал тогтворгүй

ХАБЭА-н талаарх мэдлэг хомс байдал

Итгэлцэл хомс

Хөрөнгө оруулагчдын үндсэн хэрэгцээ



Бичил уурхайчдын зүгээс

Бизнес загвар буюу бизнес модель (нөөцийн тооцоолол эсвэл үнэлгээтэй)

Хуулийн дагуу зохион байгуулалтад орж, албажсан бичил уурхайн байгууллага

Чадварлаг удирдлага



Бодлого тодорхойлогчид болон төр засгийн зүгээс

Үйл ажиллагаагаа албажуулж, олборлолт хийх эрх/зөвшөөрөл олгох

Бичил уурхайд баримтлах байгаль орчин, нийгэм болон засаглалын шалгуур/стандартыг тогтоох

Тогтвортой хууль эрх зүйн орчин



Алтны худалдаа, Ховд аймгийн Алтай сум

Өргөн хүрээнд үр нөлөө үзүүлэх боломж

Дэлхий дээрх нийт алтны нийлүүлэлтийн 20 хувь нь бичил уурхайгаас бүрддэг бөгөөд жил бүр нийт 20-30 тэрбум ам.доллартай тэнцэхүйц хөрөнгийг бий болгодог. Алтны үнэ болон хэрэгцээ тогтмол өсөж байгаатай холбогдуулан зөв технологи, зөв мэдлэгт хөрөнгө оруулснаар бүтээмж дээшилж, хөрөнгө оруулалтын жишиг загварыг бий болгож, алтны нийлүүлэлтийн сүлжээний зүгээс байгаль орчин болон нийгэмд үзүүлэх эрсдлийг бууруулж, эцэст нь дэлхийн мөнгөн усны ялгарлыг бодитоор багасгах үр нөлөөтэй юм.

Бичил уурхайг сайжруулах, хариуцлагажуулахад дэмжлэг үзүүлснээр НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай үйл ажиллагаагаа нийцүүлэн, орон нутгийн ядуурлыг бууруулж, байгаль орчны доройтлыг зогсооход хувь нэмэр оруулах боломж хөрөнгө оруулагчдын хувьд бий болно.

Санхүүгийн механизм

Бичил уурхайчдад хөрөнгө оруулах боломжит талууд болон санхүүгийн механизмууд:

- ▶ Бичил санхүүгийн байгууллага
- ▶ Арилжааны банк
- ▶ Хөгжлийн банк
- ▶ Нийгмийн хариуцлагатай хөрөнгө оруулалт
- ▶ Жижиг хөрөнгө оруулагч
- ▶ Хувь хөрөнгө оруулагч/Хувийн хөрөнгө оруулалтын сан
- ▶ Салбарын хамтрагч
- ▶ Төрийн бус байгууллага
- ▶ Хөрөнгө оруулалтын сан/сангийн зохицуулагч нар
- ▶ Мэргэжлийн хөрөнгө оруулагч институци

Дэлгэрэнгүй мэдээллийг planetgold.org хуудаснаас авна уу.



Санхүүжүүлэгч:



Үндсэн хэрэгжүүлэгч:



Хамтран хэрэгжүүлэгч:



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

